

“СҮҮ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12-р сарын 03-ны өдөр

№ 22

Улаанбаатар хот

ХАЛААСНЫ ХУВЬЦААГ ДАХИН ГАРГАЖ, ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.13 дахь хэсэг болон 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Сүү ХК-ийн халаасны хувьцаанаас 500,000 (Таван зуун мянга) ширхэг хүртэлх хувьцааг дахин гаргаж, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалахыг зөвшөөрсүгэй.

2. Хувьцааны арилжааг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн тухайн өдрийн зах зээлийн ханшаар хэсэгчлэн худалдахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдээллийг хүргүүлж, халаасны хувьцааг дахин гаргахтай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын дагуу Компанийн халаасны хувьцаанаас худалдсан энгийн хувьцааг хасч, компанийн санхүүгийн данс бүртгэлд тусгахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д болон Санхүүгийн алба /Э.Уянга/-нд даалгасугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Баярбаатар/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д. ГАНБААТАР